



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 09 болон 10 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 03-р сарын 05-аас 03-р сарын 19-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 4 дэх дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас 2021 оны 3-р сарын 9-ний өдрийн тайландаа **дэлхийн эдийн засаг 2021 онд 5.6 хувиар, 2022 онд 4.0 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Улс орнууд цар тахлын нөхцөлд үйл ажиллагаа явуулахад илүү дасан зохицож, 2020 оны сүүлээс худалдаа, аж үйлдвэрлэл эрчимжиж байгаагийн зэрэгцээ вакцинжуулалт эхэлсэн тул ЭЗХАХБ-

аас 2021 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх улирлаас 1 гаруй нэгж хувиар ахиуллаа. Гэсэн хэдий ч өсөлтийн төлөв улс орнууд болон эдийн засгийн секторуудын хувьд харилцан адилгүй байна. Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлээс гарахад дэлхий даяар вакцинжуулалтыг түргэсгэх, улс орон бүрт вакцины хүрэлцээг нэмэгдүүлэх нь чухал болохыг онцолжээ.

**Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентлагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд**

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	2021 он				
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ-ын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	OECD	3/9/2021	<b>5.6%</b>	7.8%	6.5%	3.9%	2.7%
2	Fitch	3/17/2021	6.1%	8.4%	6.2%	4.7%	3.3%
3	Oxford economics	3/10/2021	<b>6.0%</b>		7.0%		
4	KPMG	3/15/2021	<b>5.0%</b>	8.8%	5.9%	4.2%	2.9%

*Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудаснууд*



- **Фитч агентлаг 3-р сарын 17-ны өдрийн тайландаа дэлхийн эдийн засаг 2021 онд 6.1 хувиар өсөхөөр төсөөллөө шинэчиллээ.** Энэ нь өмнөх 12-р сарын төсөөллөөс 0.8 нэгж хувиар сайжирсан төсөөлөл юм. Өмнөх төсөөллөөс хойш дэлхий нийтээр вакцинжуулалт эхэлсэн, АНУ 1.9 их наяд ам.долларын буюу дэлхийн ДНБ-ий 2.5 хувьтай тэнцэх төсвийн багцыг баталсан нь төсөөллийг сайжруулахад голлон нөлөөлөв.
- **Брексит болон КОВИД-19-ийн нөлөөгөөр Их Британийн гадаад худалдааны эргэлт буурав.** Тухайлбал, Их Британийн барааны экспорт 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар агшсан бөгөөд үүн дотроо Европын Холбоо руу гаргасан экспорт 40.7 хувиар агшжээ. Их Британийн барааны импорт 2021 оны 1-р сард 21.6 хувиар агшсан бөгөөд үүн дотроо Европын Холбооноос авсан импорт 28.8 хувиар буурчээ. Түүнчлэн, цар тахлын тархалтыг хумих зорилгоор Их Британийн эдийн засаг 1-р сарын дийлэнх хугацаанд хөл хорионд байсан тул Брекситийн дараах гаалийн шинэ дүрэм журамтай холбоотой гадаад худалдаанд ирэх сөрөг нөлөөг хөл хорионы нөлөөнөөс ялгахад хүндрэлтэй байна. Экспортыг бүтээгдэхүүнээр задалж үзвэл загас, мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн, хувцас, гутал, автомашины экспортын агшилт гол бууралтыг бий болгожээ.
- АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ) 3-р сарын 16-17-нд хуралдаж, ХНБ-ны хүүг 0-0.25 хувийн интервалд хэвээр хадгалах, сард 120 тэрбум ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрөө үргэлжлүүлэхээр шийдэв. Мөн хөдөлмөрийн захын нөхцөл сайжирч, урт хугацааны бүрэн ажил эрхлэлтийн түвшин болон инфляцын 2

хувийн түвшинг хангах хүртэл ХНБ-ны хүүг хэвээр хадгалахаа мэдэгдлээ. ХНБ-аас төсөв, мөнгөний тэлэх бодлого болон вакцинжуулалтын нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг энэ онд 6.5 хувиар (өмнөх улирлын төсөөллөөс 2.3 нэгж хувиар өндөр) өсөхөөр төсөөлж байна.

- Европын төв банк 3-р сарын 11-ний өдрийн мөнгөний бодлогын зөвлөл (Удирдах зөвлөл)-ийн хурлаар 1) "Цар тахлын үед яаралтай тусламжийн арга хэмжээ авах хөтөлбөр (PEPP)"-ийн хүрээнд бонд худалдан авалтын дүнг 2022 оны 3-р сарыг хүртэл 1.85 их наяд еврод хүргэх, ирэх улиралд бонд худалдан авалтыг 1-р улирлаас нэмэгдүүлэх 2) "Хөрөнгө худалдан авалтын хөтөлбөр (APP)"-ийн хүрээнд сар бүр 20 тэрбум еврогийн бонд худалдан авалтыг үргэлжлүүлэх 3) Төв банкны дахин санхүүжилтийн хүү, овернайт зээлийн хүү болон хадгаламжийн хүүг 0 хувь, 0.25 хувь, - 0.5 хувьд тус тус хэвээр үлдээхээр шийдэв. Европын Төв банк инфляц зорилтот 2 хувийн орчимд хүртэл хүүг одоогийн түвшинд хадгалж, эдийн засгийг дэмжих багц хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэхээ мэдэгдэв.

#### **Эх сурвалж:**

1. SXcoal, [Russian Jan coking coal exports to China plunge MoM](#)
2. SXcoal, [China Jan-Feb coking coal imports down 58.1% on yr](#)
3. SXcoal, [China Jan-Feb coking coal imports down 58.1% on yr](#)
4. Oxford Economics, [Stronger recovery will not unleash inflation](#)
5. Globalization Institute Federal Reserve Bank of Dallas, [Global economic conditions](#)
6. European Central Bank, [Monetary policy decisions](#)
7. Office for National Statistics, [UK trade-January 2021](#)



## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын эрх баригчид мөнгөний бодлогыг хэвийн горимд хадгалах бодлого баримталж байна.** БНХАУ-ын Ардын Банк (ХАБ)-аас бодлогын хүү (1 жилийн LPR)-г 2021 оны 3-р сард 3.85 хувьд, 1 жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хэрэгслийн хүүг 2.95 хувьд, 5 жилийн хугацаатай орон сууцны зээлийн жишиг хүүний түвшинг 4.65 хувьд тус тус хэвээр үлдээснээр хүүний түвшин сүүлийн 11 сар дараалан тогтвортой байна. Хүүний одоогийн түвшин нь эдийн засгийн сэргэлтийг дэмжихийн зэрэгцээ алгуур мөнгөний бодлогыг хэвийн горимд хадгалах чиглэл баримтлах, болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд тохиромжтой түвшин гэж ХАБ-ны Ерөнхийлөгч И Ганг мэдэгдэв. ХАБ энэ оны туршид хүүг одоогийн түвшинд хэвээр хадгалах төлөвтэй ч дотоод эрэлт цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байгаа тул оны сүүлийн хагаст хүүг 0.1 нэгж хувиар бууруулах магадлалтайг Блүүмбергийн шинжээчид онцолж байна.
- **БНХАУ-ын коксжих нүүрсний импорт** 2021 оны эхний 2 сард 6.4 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 58.1 хувиар, мөнгөн дүнгээр \$6.7 тэрбум ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 67.9 хувиар тус тус **буурав**. БНХАУ-ын **хүрэн нүүрсний** импорт оны эхний 2 сард 17.3 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 34.5 хувь, мөнгөн дүнгээр \$1.1 тэрбум ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар тус тус буурав.
- ОХУ нь БНХАУ уруу экспортлох нүүрсний экспортоо эрчимжүүлж, 2020 оны 10-р сараас хойш БНХАУ-ын Засгийн газраас Австрали улсын нүүрсний экспортод гаалийн хязгаарлалт тавьснаар үүсч буй зах зээлийн шинэ орон зайн зарим хэсгийг нөхөхийг зорьж байгааг Sxcoal агентлаг онцлов. Ийнхүү зах зээлээ тэлэхэд тээвэрлэлтийн асуудал гол бэрхшээл болж байгаа тул ОХУ-ын эрх баригчид Саха (Якут)-ын нутгаас БНХАУ уруу нийлүүлэгдэх нүүрсний экспортыг хөнгөвчлөх зорилгоор шинэ төмөр зам барих зөвшөөрлийг “Оросын төмөр зам”-д олгоод байна.
- БНХАУ-ын Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд Тангшан хот дахь 23 ган үйлдвэрлэгчдийг 3-р сарын 20-ний өдрөөс он дуустал үйлдвэрлэлээ хамгийн багадаа 30 хувиар бууруулах чиглэл өгөөд байна. Ийнхүү тус арга хэмжээний нөлөөгөөр Тангшан хотын түүхий гангийн үйлдвэрлэл 10 хувь, ширэм болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1-2 хувиар буурах төлөвтэй. Тангшаны ширэм болон бусад ган бүтээгдэхүүнүүд БНХАУ-ын нийт ган бүтээгдэхүүний 15 хувь, 12.7 хувийг тус тус эзэлж байна. Иймд ган үйлдвэрлэлд түлхүү ашиглагддаг **коксжих нүүрсний эрэлт энэ онд буурч болзошгүй** байна.
- **Автомашинны үйлдвэрлэл болон худалдаа** 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 34.6 хувь, 29.5 хувиар тус тус өслөө.
- Цар тахлын халдвар эрчимтэй нэмэгдэж буй нөлөөгөөр гаалийн хяналт шалгалт чангарч Монголоос импортлох коксжих нүүрсний хэмжээг бууруулаад байна. Гашуун сухайт боомтоор нэвтэрч буй ачааны машины тоо 2021 оны 2-р сард өдрийн 330 болж өмнөх сараас 17.8 хувиар буурав.

### Эх сурвалж:

1. *China React: LPRs, PBOC Hints Suggest Steady to Looser Stance, Bloomberg*

3

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН  
ӨӨРЧЛӨЛТ**

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/03/19	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	9067.5	0.1%	-1.0%	-0.7%	16.2%	96.2%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж байгаа нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ өндөр байхад нөлөөлж байна.
<b>Төмрийн хүдэр</b>	157	0.0%	0.6%	-4.0%	2.8%	96.6%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй тул үнэ өндөр түвшинд хадгалагдаж байна.
<b>Алт</b>	1745	-0.3%	0.5%	-3.8%	-8.4%	12.0%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт хийгдэж буй нь зах зээлд дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ буурахад нөлөөлж байна.
<b>Газрын тос (Брент)</b>	64.5	0.2%	-6.1%	-1.1%	26.6%	139.3%	ОПЕК+-ийн нэгдэл нийлүүлэлтээ 4, 5-р үргэлжлүүлэн бууруулах төлөвтэй ч Европын Холбооны улс орнуудад цар тахлын тархалт дахин эрчимжсэнээр хөл хорио тогтоохоор байгаа нь эрэлтийг бууруулж үнийг бууруулах чиглэлд нөлөөлж байна.